



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025.04.11 № 287/995
танай _____-ны № _____-г

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
П.САЙНЗОРИГ, Б.ЭНХБАЯР,
З.МЭНДСАЙХАН НАР ТАНАА

Асуултын хариу хүргүүлэх тухай

Таны 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 13 тоот асуултад дараах хариуг хүргүүлж байна.

1. Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2023 оны тайланд дурдсанаар улсын хэмжээнд 4,271 төрийн байгууллагад нийт 228,820 төрийн албан хаагч ажиллаж байна гэсэн тоон мэдээлэл байгаа бөгөөд 2025 оны эхний улирлын байдлаар улсын хэмжээнд хэдэн төрийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа, тэдгээрт ажиллаж буй төрийн албан хаагчдын тоо нэмэгдсэн эсэх талаарх мэдээлэл:

2023 оны байдлаар төрийн 4,239 байгууллагад нийт 226,496 төрийн албан хаагч ажилласны 3,898 нь төрийн улс төрийн, 21,639 нь төрийн захиргааны, 47,657 нь төрийн тусгай, 135,302 нь төрийн үйлчилгээний албан хаагч тус тус байсан бол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар төрийн 4,276 байгууллагад нийт 226,895 төрийн албан хаагч, үүнээс 3,823 нь төрийн улс төрийн, 21,350 нь төрийн захиргааны, 49,081 нь төрийн тусгай, 152,641 нь төрийн үйлчилгээний албан хаагч тус тус ажилласан байна.

Харин 2025 оны эхний улирлын байдлаар төрийн 4,306 байгууллагад нийт 227,996 төрийн албан хаагч ажиллаж байгаа бөгөөд үүний 3,919 нь төрийн улс төрийн, 21,519 нь төрийн захиргааны, 49,181 нь төрийн тусгай, 153,377 нь төрийн үйлчилгээний албан хаагч тус тус байна.

Тоо бүртгэлийн 2025 оны эхний улирлын мэдээг 2023 оны тайлантай харьцуулж үзэхэд төрийн байгууллагын тоо 67, төрийн албан хаагчийн тоо 1,500 хүнээр нэмэгдсэн байна. Тухайлбал, төрийн улс төрийн албан хаагч 21, төрийн тусгай албан хаагч 1,524, төрийн үйлчилгээний албан хаагч 75 хүнээр тус тус нэмэгдсэн бол төрийн захиргааны албан хаагчийн тоо 150 хүнээр буурсан дүнтэй байна.

2. ... хуулиар чиг үүргийг нь тодорхойлоогүй болон Засгийн газрын гишүүн, яам, агентлагийн чиг үүрэгтэй давхардсан зөвлөл, төв, хороо, комисс зэрэг нэршилтэй хэдэн байгууллага байгаа, бүтэц, орон тоо, зохион байгуулалтын чиг үүргийг баталсан шийдвэрүүд, төрийн албаны шалгалт, сонгон шалгаруулалтаар томилогдсон эсэх, тэдгээр байгууллагад олгосон төсвийн хөрөнгө, зарцуулалт, тэр дундаа цалин хөлс болон бусад үйл ажиллагааны зардлын хэмжээний талаарх мэдээлэл:

110255005832

Монгол Улсын Засгийн газраас нийт 57 хороо, комисс, зөвлөлийг байгуулснаас Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид тухайлан заасан 43 хороо, комисс, зөвлөл чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна.

Харин хуулиар чиг үүргийг нь тухайлан заагаагүй 10 хороо, 4 зөвлөлийг Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Засгийн газар шаардлагатай бол зөвлөл, ажлын бусад албыг байгуулж зардлынхаа төсөвт багтаан ажиллуулж болно.” гэж заасны дагуу хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан тэргүүлэх чиглэлийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд үүссэн асуудлыг тусгайлан зохицуулах, эсхүл нэгдсэн зохицуулалт, салбар хоорондын уялдааг хангах зайлшгүй шаардлагыг харгалзан тодорхой зорилгоор байгуулсан.

Эдгээр хороо, зөвлөл нь тухайн зорилго хангагдаж, тусгайлсан зохицуулалтын шаардлагагүй болсон нөхцөлд татан буугдах буюу түр хугацаагаар байгуулагддаг онцлогтой.

Мөн эдгээр хороо, зөвлөлийн үйл ажиллагааны цар хүрээ, чиг үүргийн давхардал, ажлын ачааллыг харгалзан 6 хороо, 1 зөвлөлд ажлын алба байгуулсан бөгөөд тэдгээрт нийтдээ 90 хүний орон тоотой ажиллуулахаас 2025 оны эхний улирлын байдлаар 73 хүн ажиллаж байна.

Хороо, зөвлөлд ажиллах албан хаагчийг Төрийн албаны хуулиар зохицуулаагүй тул ангилал, зэрэглэлийг тогтоогоогүй бөгөөд хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байна (“Хүснэгт-1”).

Хүснэгт-1

Хороо, зөвлөл, түүний ажлын албаны орон тоо, төсөв, цалингийн зардлийн мэдээлэл

Д/д	Үндэсний хороо, зөвлөлийн нэр	Ажлын албаны батлагдсан орон тоо	Ажиллаж байгаа орон тоо	Тайлбар	2025 оны төсөв	Цалин хөлс
1	Монгол Улсын олон улс дахь сурталчилгаа, мэдээллийн үндэсний хороо	5	3		10,078.5	200.0
2	Олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хүрээнд ажиллах Засгийн газрын комисс, хороо (5 комисс, хороо)	0	0	Засгийн газраас байгуулсан 5 комисс, хорооны даргаар тухайн асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүн ажилладаг, ажлын албагүй		
3	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэсний хороо	0	0	Ажлын албаны чиг үүргийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Авлигатай тэмцэх газраас хэрэгжүүлдэг		
4	"Хархорум хотын" бүтээн байгуулалтын үндэсний хороо	0	0	Ажлын албаны чиг үүргийг Хархорум хотын захирагчийн		

				Ажлын албанаас хэрэгжүүлдэг		
5	Үндэсний баялгийн сан, орон сууцжуулалтын үндэсний хороо	15	9		2,064.4	980.0
6	Шинэ хоршоо хөдөлгөөний салбар дундын уялдааг хангах үндэсний хороо	15	15		2,645.2	988.1
7	Эрчим хүчний реформыг удирдан зохион байгуулах үндэсний хороо	10	9		9,350.2	576.6
8	Аж үйлдвэржилтийн үндэсний хороо	15	15		2,646.0	721.5
9	"Алсын хараа" 2050 Салбар дундын уялдааг хангах үндэсний хороо	15	11		2,409.1	1,056.6
10	Цөлжилттэй тэмцэх тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенцын оролцогч Талуудын 17 дугаар Бага хурал (COP17)-ыг 2026 онд Монгол Улсад зохион байгуулах ажлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, салбар хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий үндэсний хороо	0	0	Ажлын албаны чиг үүргийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Онцгой байдлын ерөнхий газраас хэрэгжүүлдэг		
11	Нээлттэй засгийн түншлэлийн үндэсний зөвлөл	0	0	Ажлын албаны чиг үүргийг Төрийн хэмнэлт, бүтээмжийн зөвлөлийн Ажлын албанаас хэрэгжүүлдэг		
12	Өмнийн говийн бүсийн хөгжлийн зөвлөл	0	0	Ажлын албаны чиг үүргийг Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны Ажлын албанаас хэрэгжүүлдэг		

13	Сансрын бодлогын үндэсний зөвлөл	0	0	Ажлын албаны чиг үүргийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас хэрэгжүүлдэг		
14	Төрийн хэмнэлт, бүтээмжийн зөвлөл	15	11		935.6	935.6
	Дүн	90	73		30,129.0	5,458.4

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 52, 54 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Засгийн газрын хороо, зөвлөл, комиссын үйл ажиллагааны үр дүн, зорилго, чиг үүргийн давхардлын асуудлыг нягтлан судлах ажил хийгдэж байна.

3. ... төрийн өмчит компани, банк, улсын үйлдвэрийн газарт "бүтээмжийн менежер", "хяналтын менежер" гэх нэршил бүхий хэдэн албан тушаалыг бий болгосон, хэдэн хүн томилогдсон, томилсон эдгээр шийдвэр, тэдгээрийн цалин хөлс, бусад хангамж, сонгон шалгаруулалтаар томилогдсон эсэх, сонгон шалгаруулалтаар томилогдсон бол холбогдох мэдээллийг бичгээр ирүүлэх:

Монгол Улсын Засгийн газар 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаараа төрийн өмчит хуулийн этгээдийн нөхцөл байдал, тулгамдсан асуудал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар асуудалтай танилцаад хуралдааны тэмдэглэлээр "Төрийн өмчит хуулийн этгээдийн өмчийн удирдлага, засаглал, хяналтын тогтолцоог сайжруулах, бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор төрийн өмчит хуулийн этгээдийн бүтэц, зохион байгуулалтад засаглал, ил тод байдал, комплаенсийн болон гүйцэтгэлийн үнэлгээ, дотоод аудитын хяналт хариуцсан удирдлагын чиг үүргийг бий болгож, холбогдох хуульд заасан журмын дагуу шаардлага хангасан эрх бүхий албан тушаалтныг томилон ажиллуулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч Засгийн газрын холбогдох гишүүд, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл) нарт" даалгасан.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас ирүүлсэн мэдээлэлд дурдсанаар 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн байдлаар төрийн өмчит хуулийн этгээдүүдэд 42 менежер томилогдон ажиллаж байна.


Жич: Хороо, комисс, зөвлөл байгуулсан Засгийн газрын шийдвэрийг хавсаргав.

Хавсралт 41 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Н.УЧРАЛ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 08 сарын 07 өдөр

Дугаар 21

Улаанбаатар хот

Засгийн газрын Үндэсний хороо, комисс, Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1, Агаарын тухай хуулийн 6.1.2, 6.2, Автотээврийн тухай хуулийн 5.1.6, Аялал жуулчлалын тухай хуулийн 20.2, Биеийн тамир, спортын тухай хуулийн 18.2, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 6.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22.3, 22.9, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 14.3, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 18.2, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21³.6, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 7.1, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 22.1, 22.2, Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 11.3, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 14.6, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 22¹.1, Боловсролын ерөнхий хуулийн 23.3, 24.1.9, Оюуны өмчийн тухай хуулийн 10.3, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 13.1.9, Усны тухай хуулийн 9¹.3, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 15.1.3, Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 6.2, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 41.2, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн 8.3, Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хуулийн 4.1.3, Хүнсний тухай хуулийн 18.4, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16.1, 16.2, Хэмжил зүйн тухай хуулийн 18.2, Цөмийн энергийн тухай хуулийн 10.3, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 6.1, Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 7.3-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 1 дүгээр, Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих сангийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2 дугаар, Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 3 дугаар, Боловсролын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 4 дүгээр, Бүсчилсэн хөгжлийн үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 5 дугаар, Гаалийн тарифын зөвлөлийн бүрэлдэхүүнийг 6 дугаар, Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 7 дугаар, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг 8 дугаар, Допингийн эсрэг үндэсний зөвлөл (платформ)-ийн бүрэлдэхүүнийг 9 дүгээр, Дэлхийн өвийн үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 10 дугаар, Жендэрийн үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 11 дүгээр, Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 12 дугаар, Замын хөдөлгөөний

аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 13 дугаар, Кибер аюулгүй байдлын зөвлөлийн бүрэлдэхүүнийг 14 дүгээр, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 15 дугаар, Монгол Улсын олон улс дахь сурталчилгаа, мэдээллийн үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 16 дугаар, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 17 дугаар, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 18 дугаар, Нээлттэй засгийн түншлэлийн үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 19 дүгээр, Олимп, паралимпын наадамд оролцох үндэсний шигшээ багийн бэлтгэл ажлыг зохион байгуулалтаар хангах үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 20 дугаар, Оюуны өмчийн үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 21 дүгээр, Өмнийн говийн бүсийн хөгжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг 22 дугаар, Сансрын бодлогын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 23 дугаар, Төрийн бүтээмжийн үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 24 дүгээр, Улсын онцгой комиссын бүрэлдэхүүнийг 25 дугаар, Усны үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 26 дугаар, Уур амьсгалын үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 27 дугаар, Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооны бүрэлдэхүүнийг 28 дугаар, Үндэсний тээврийн хорооны бүрэлдэхүүнийг 29 дүгээр, Химийн хорт болон аюултай бодисын бодлого, зохицуулалтын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 30 дугаар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн бүрэлдэхүүнийг 31 дүгээр, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг 32 дугаар, Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх үйл ажиллагааг улсын хэмжээнд зохицуулан зохион байгуулах үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 33 дугаар, Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 34 дүгээр, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 35 дугаар, Хэмжил зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг 36 дугаар, Цөмийн энергийн комиссын бүрэлдэхүүнийг 37 дугаар, Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 38 дугаар, "Шинэ хархорум" хотын бүтээн байгуулалтын үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 39 дүгээр, Олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хүрээнд ажиллах Засгийн газрын комисс, хороо, тэдгээрийн даргыг 40 дүгээр хавсралт ёсоор тус тус баталсугай.

2.Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт, эсхүл холбогдох бусад хууль тогтоожид тусгайлан заасны дагуу байгуулагдсан болон энэ тогтоолын 1-д зааснаас бусад Засгийн газрын тогтоолоор байгуулсан үндэсний хороо, комисс, зөвлөлийг татан буулгасугай.


3.Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт орсонтой холбогдуулан Хүний эрхийг хангах үндэсний хорооны чиг үүргийг Төрийн бүтээмжийн үндэсний хороонд шилжүүлэн, Төрийн бүтээмжийн үндэсний хорооны Ажлын албаны орон тооны хязгаарыг 15 байхаар тогтоож, түүний үйл ажиллагаанд шаардагдах зардлыг Монгол Улсын 2024 оны төсвийн тодотголд тусгаж, цаашид жил бүрийн улсын төсөвт тусгах арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгасугай.

4.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан "20 минутын хот Үндэсний хорооны бүрэлдэхүүн, дүрэм, Сайдын Ажлын албаны орон тооны хязгаарыг батлах тухай" Засгийн газрын 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 08 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "20 минутын хот Үндэсний хорооны бүрэлдэхүүн"-ий Гишүүд хэсэгт "Гишүүд:" гэсний дараа "Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан (зөвшилцсөнөөр);" гэж нэмсүгэй.

5.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан "Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа байгуулах тухай" Засгийн газрын 2021 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 234 дүгээр тогтоолын 4 дэх заалтын "хамтран ажиллахыг" гэсний дараа "Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга Р.Эрдэнэбүрэн," гэж нэмж, мөн тогтоолын 2 дахь заалтын "Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатарт" гэснийг "Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга Р.Эрдэнэбүрэнд" гэж өөрчилсүгэй.

6.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учралд даалгасугай.

7.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан "Засгийн газрын үндэсний хороо, комисс, үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 350 дугаар тогтоол, "Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг батлах, тогтоолд нэмэлт оруулах тухай" Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 295 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Н.УЧРАЛ

Засгийн газрын 2024 оны 08 дугаар
сарын 07-ны өдрийн 21 дүгээр
тогтоолын 1 дүгээр хавсралт

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ҮНДЭСНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: -Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга
- Дэд дарга: -Авлигатай тэмцэх газрын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх хэлтсийн дарга
- Гишүүд: -Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх;
- Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

- Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Монгол Улсын Шадар сайд /бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал хариуцсан/-ын Ажлын албаны дарга;
 - Монгол Улсын Шадар сайд /гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан/-ын Ажлын албаны дарга;
 - Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны Ажлын албаны дарга;
 - 20 минутын хот Үндэсний хорооны Ажлын албаны дарга;
 - Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны Ажлын албаны дарга.
- Нарийн бичгийн дарга:
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Архив, нууц, албан хэрэг хөтлөлтийн хэлтсийн дарга;
 - Авлигатай тэмцэх газрын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх хэлтсийн албаны дарга.

Засгийн газрын 2024 оны 08 дугаар
сарын 07-ны өдрийн 21 дүгээр
тогтоолын 16 дугаар хавсралт

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛС ДАХЬ СУРТАЛЧИЛГАА, МЭДЭЭЛЛИЙН
ҮНДЭСНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: -Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд
- Дэд дарга: -Гадаад харилцааны сайд
- Гишүүд: -Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд;
- Монгол Улсын Шадар сайд /гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан/;
- Сангийн сайд;
- Хууль зүй, дотоод хэргийн сайд;
- Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд;
- Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд;
- Зам, тээврийн сайд;
- Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд;
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах газрын дарга;
- Зэвсэгт хүчний Жанжин штабын орлогч дарга;
- Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн ерөнхий захирал;
- МОНЦАМЭ агентлагийн захирал (зөвшилцсөнөөр);
- “Шинэ сэргэлтийн бодлогын хурдасгуур төв” УТУГ-ын гүйцэтгэх захирал.
- Нарийн бичгийн дарга: -Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Гадаад харилцаа, олон улсын мэдээлэл сурталчилгаа, хамтын ажиллагааны газрын дарга

Засгийн газрын 2024 оны 08 дугаар
сарын 07-ны өдрийн 21 дүгээр
тогтоолын 19 дүгээр хавсралт

НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНЦЛЭЛИЙН ҮНДЭСНИЙ
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: -Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга
- Гишүүд: -Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх;
- Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны Ажлын албаны дарга;
 - Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга /төсөл, хөтөлбөр хариуцсан/;
 - Авлигатай тэмцэх газрын дэд дарга;
 - Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын ерөнхийлөгч (тохиролцсоноор);
 - Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвийн ерөнхий захирал (тохиролцсоноор);
 - Нээлттэй нийгэм форумын гүйцэтгэх захирал (тохиролцсоноор);

-Хүний эрх, хөгжил төвийн тэргүүн;
(тохиролцсоноор);

-“Транспэрэнси Интернэшнл Монгол” төрийн бус
байгууллагын гүйцэтгэх захирал (тохиролцсоноор);

-“Нээлттэй засаглалын түншлэл”-ийн Олон улсын
элч төлөөлөгч (тохиролцсоноор).

Нарийн бичгийн
дарга:

-Төрийн бүтээмжийн үндэсний хорооны
Ажлын албаны дарга.

---oOo---

Засгийн газрын 2024 оны 08 дугаар
сарын 07-ны өдрийн 21 дүгээр
тогтоолын 22 дугаар хавсралт

ӨМНИЙН ГОВИЙН БҮСИЙН ХӨГЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: -Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн
Үндэсний хорооны дарга
- Гишүүд: -тухайн тойргоос сонгогдсон Улсын Их Хурлын
гишүүн (зөвшилцсөнөөр);
- тухайн тойргоос сонгогдсон Улсын Их Хурлын
гишүүн (зөвшилцсөнөөр);
- Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн
засаг, хөгжлийн сайд;
- Сангийн сайд;
- Боловсролын сайд;
- Зам, тээврийн сайд;
- Өмнөговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын дарга;
- Өмнөговь аймгийн Засаг дарга;
- Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх;
- Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн
нарийн бичгийн дарга;
- Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн
яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны
Төрийн нарийн бичгийн дарга;
- Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн
дарга;
- Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын
яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны
Төрийн нарийн бичгийн дарга;

-Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын Засаг дарга;

-Өмнөговь аймгийн Даланзадгад сумын Засаг дарга;

-Өмнөговь аймгийн Манлай сумын Засаг дарга;

-Өмнөговь аймгийн Номгон сумын Засаг дарга;

-Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Засаг дарга;

-Өмнөговь аймгийн Ханбогд сумын Засаг дарга;

-Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Засаг дарга;

-Өмнөговь аймгийн Хүрмэн сумын Засаг дарга;

-“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирал;

-“Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирал;

-“Оюутолгой” ХХК-ийн Санхүү эрхэлсэн дэд захирал (тохиролцсоноор);

-“Монголын алт” (МАК) ХХК-ийн дэд ерөнхийлөгч (тохиролцсоноор);

-“Энержи Ресурс” ХХК-ийн гүйцэтгэх захирал (тохиролцсоноор);

-“Монголын уул уурхайн үндэсний ассоциаци”-ийн гүйцэтгэх захирал (тохиролцсоноор);

-“Монголын логистикийн холбоо”-ны тэргүүн (тохиролцсоноор).

Нарийн бичгийн дарга

-Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны Ажлын албаны дарга.

Засгийн газрын 2024 оны 08 дугаар
сарын 07-ны өдрийн 21 дүгээр
тогтоолын 23 дугаар хавсралт

САНСРЫН БОДЛОГЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: -Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга
- Дэд дарга: -Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд
- Гишүүд: -Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх;
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга /төсөл, хөтөлбөр хариуцсан/;
- Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Тагнуулын ерөнхий газрын дарга;
- Онцгой байдлын ерөнхий газрын дарга;

-Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн
ерөнхий газрын дарга.

Нарийн бичгийн
дарга:

-Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны
яамны Сансрын технологийн хэрэгжилтийн
хэлтсийн дарга

---oOo---

Засгийн газрын 2024 оны 08 дугаар
сарын 07-ны өдрийн 21 дүгээр
тогтоолын 39 дүгээр хавсралт

“ШИНЭ ХАРХОРУМ” ХОТЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН
ҮНДЭСНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: -Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга
- Дэд дарга: -Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд
- Гишүүд:
- Сангийн сайд;
 - Зам, тээврийн сайд;
 - Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд;
 - Эрчим хүчний сайд;
 - Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга (зөвшилцсөнөөр);
 - Архангай аймгийн Засаг дарга;
 - Өвөрхангай аймгийн Засаг дарга;
 - Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх;
 - Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга;
 - Усны газрын дарга;
 - Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны Ажлын албаны дарга;

-Зэвсэгт хүчний Жанжин Штабын нэгдүгээр орлогч дарга;

-“Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын Хот байгуулалт, зураг төслийн институтын эрхлэгч;

-Архангай аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга;

-Өвөрхангай аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга.

Нарийн бичгийн дарга:

-“Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга.


---oOo---

Засгийн газрын 2024 оны 08 дугаар
сарын 07-ны өдрийн 21 дүгээр
тогтоолын 40 дүгээр хавсралт

ОЛОН УЛСЫН ГЭРЭЭГЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН ХҮРЭЭНД АЖИЛЛАХ
ЗАСГИЙН ГАЗРЫН КОМИСС, ХОРОО, ТЭДГЭЭРИЙН ДАРГА

№	Комисс, хороо, ажлын хэсэг	Дарга
1.	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (ФАО)-ын асуудал эрхэлсэн Монголын комисс	Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
2.	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Үйлдвэр хөгжлийн байгууллага (ЮНИДО)-ын Монголын үндэсний хороо	Хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
3.	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (ЮНЕСКО)-ын Монголын үндэсний комисс	Гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
4.	Биоаюулгүй байдлыг хангах үндэсний хороо	Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
5.	Дэлхийн худалдааны байгууллагын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах үүрэг бүхий Үндэсний хороо	Гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн

----oOo----



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 07 сарын 24 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот


Үндэсний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор салбарын үйл ажиллагааны уялдаа холбоог хангаж, нэгдсэн удирдлагаар хангах үүрэг бүхий "Алсын хараа 2050" салбар дундын уялдааг хангах Үндэсний хороог байгуулж, Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралт, Үндэсний хорооны ажиллах журмыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.


2. "Алсын хараа 2050" салбар дундын уялдааг хангах Үндэсний хорооны Ажлын албаны орон тооны хязгаарыг 15 байхаар тогтоосугай.

3. Энэ тогтоолын 2-т заасан Ажлын албаны үйл ажиллагааны зардлыг Монгол Улсын 2024 оны төсвийн тодотголд тусгаж, цаашид жил бүрийн улсын төсөвт тусгах арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгасугай.



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Н.УЧРАЛ



Засгийн газрын 2024 оны 07 дугаар
сарын 24-ний өдрийн 09 дүгээр
тогтоолын 1 дүгээр хавсралт

**"АЛСЫН ХАРАА 2050" САЛБАР ДУНДЫН УЯЛДААГ ХАНГАХ
ҮНДЭСНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН**

- Дарга: -Монгол Улсын Ерөнхий сайд.
- Гишүүд: -Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг,
хөгжлийн сайд;
- Монгол Улсын Шадар сайд (гадаад худалдаа, хөрөнгө
оруулалтын асуудал хариуцсан);
- Монгол Улсын Шадар сайд (бүсчилсэн хөгжил, онцгой
байдлын асуудал хариуцсан);
- Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх
газрын дарга;
- Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны
дарга;
- Гадаад харилцааны сайд;
- Сангийн сайд;
- Хууль зүй, дотоод хэргийн сайд;
- Батлан хамгаалахын сайд;
- Боловсролын сайд;
- Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд;
- Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд;
- Ч.Анар-Улсын Их Хурлын гишүүн (зөвшилцсөнөөр);
- Ж.Баясгалан-Улсын Их Хурлын гишүүн (зөвшилцсөнөөр);
- П.Ганзориг-Улсын Их Хурлын гишүүн (зөвшилцсөнөөр);
- А.Ганбаатар-Улсын Их Хурлын гишүүн (зөвшилцсөнөөр);
- Б.Жаргалан-Улсын Их Хурлын гишүүн (зөвшилцсөнөөр);
- Г.Лувсанжамц-Улсын Их Хурлын гишүүн (зөвшилцсөнөөр);

- Б.Найдалаа-Улсын Их Хурлын гишүүн (зөвшилцсөнөөр);
- О.Номинчимэг-Улсын Их Хурлын гишүүн (зөвшилцсөнөөр);
- Б.Пунсалмаа-Улсын Их Хурлын гишүүн (зөвшилцсөнөөр);
- О.Саранчулуун-Улсын Их Хурлын гишүүн (зөвшилцсөнөөр);
- Х.Тэмүүжин-Улсын Их Хурлын гишүүн (зөвшилцсөнөөр);
- Б.Уянга-Улсын Их Хурлын гишүүн (зөвшилцсөнөөр);
- С.Цэнгүүн-Улсын Их Хурлын гишүүн (зөвшилцсөнөөр);
- М.Энхцэцэг-Улсын Их Хурлын гишүүн (зөвшилцсөнөөр);
- Монгол Улсын Ерөнхий сайдын Ахлах зөвлөх;
- “Шинэ сэргэлтийн бодлогын Хурдасгуур төв”-ийн захирал.
- Д.Ганмаа-Улсын Их Хурлын гишүүн (зөвшилцсөнөөр).

Нарийн бичгийн
дарга:

----oOo----



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 09 сарын 25 өдөр

Дугаар 95

Улаанбаатар хот

Тогтоол, тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай

Үндэсний баялгийн сангийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Засгийн газрын үндэсний хороо, комисс, үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 21 дүгээр тогтоолд энэ тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Үндэсний баялгийн сан, орон сууцжуулалтын үндэсний хорооны бүрэлдэхүүн” гэсэн 41 дүгээр хавсралт, 2 дугаар хавсралтаар баталсан “Шинэ хоршоо хөдөлгөөний салбар дундын уялдааг хангах үндэсний хорооны бүрэлдэхүүн” гэсэн 42 дугаар хавсралт, 3 дугаар хавсралтаар баталсан “Эрчим хүчний реформыг удирдан зохион байгуулах үндэсний хорооны бүрэлдэхүүн” гэсэн 43 дугаар хавсралт тус тус нэмсүгэй.

2.Мөн тогтоолын 1 дэх заалтын “40 дүгээр хавсралт” гэсний дараа “, Үндэсний баялгийн сан, орон сууцжуулалтын үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 41 дүгээр хавсралт, Шинэ хоршоо хөдөлгөөний салбар дундын уялдааг хангах үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 42 дугаар хавсралт, Эрчим хүчний реформыг удирдан зохион байгуулах үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 43 дугаар хавсралт” гэж нэмсүгэй.


3.Мөн тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэсний хорооны бүрэлдэхүүн”-ий “-Дэд дарга” гэсэн хэсэгт “-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга” гэж нэмсүгэй.

4.Энэ тогтоолын 1-д заасан Үндэсний хороодын ажиллах журмыг баталж, хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Үндэсний хороодын дарга нарт тус тус даалгасугай.

5.Энэ тогтоолын 1-д заасан Үндэсний хороодын Ажлын албаны орон тооны хязгаарыг 15 хүртэл байхаар тогтоож, 2024 онд тэдгээрийн үйл ажиллагаанд шаардагдах зардлыг Засгийн газрын нөөц сангаас санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхланд даалгаж, цаашид шаардагдах зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж байхыг Засгийн газрын холбогдох гишүүдэд үүрэг болгосугай.

6. Шинэ хоршоо хөдөлгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны үлдэгдэл төлбөрийг "Шинэ сэргэлтийн бодлогын Хурдасгуур төв" УТҮГ-ын 2024 оны төсөвт батлагдсан Шинэ хоршоо хөдөлгөөн хөтөлбөр, арга хэмжээний зардлаас шийдвэрлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан нарт даалгасугай.

7. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан "Засгийн газрын агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 39 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
